



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 09 дүгээр сарын 10 өдөр

Дугаар 46

Хэрлэн сум

ХХХХVI ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 46 дугаар хурал Онцгой комиссын ажиллах журмын 1.8-д заасны дагуу цомхотгосон хэлбэрээр 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 11:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 60,0 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1."Есүс Христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн Чойбалсан цуглаан" сүмийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн ажлын дүнг танилцуулах,

Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтуяа

2."Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ний газрын тосны тээвэрлэлт хийх 25 автомашинийг БНХАУ-ын Өвдгийн боомтоор Монгол улсын хил нэвтрүүлэх тухай хүсэлтийн талаар хэлэлцэх,

Автотээврийн төвийн дарга Ц.Мөнхтөр

3."ДБЭХС ТӨХК-ийн суурилагдсан хүчин чадлыг 50МВт-р өргөтгөх" төслийн газар шороо, барилга угсралтын хэмжилтийн багажууд 2020 оны 09 дүгээр сарын 02-нд өдөр Чойбалсан хотод ирж тусгаарлагдсан 2 дахь ээлжийн хүмүүсээр ирсэн бөгөөд уг багаж хэрэгслийг тусгаарлалтын байрнаас гаргаж барилга угсралтын ажлыг эрчимжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэхийг хүссэн хүсэлтийг хэлэлцэх,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Нармандах

4.Дорнод аймгийн ЕБСургуулийн 1990 оны төгсөгчдийн 30 жилийн ойн уулзалтын хүрээнд гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулах зөвшөөрөл олгох тухай хүсэлтийг хэлэлцэх,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Нармандах

5.1989-1991 оны төгсөгчдийн спортын олон төрөлтийн тэмцээн зохион байгуулах зөвшөөрөл олгох тухай хүсэлтийг хэлэлцэх,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Нармандах

6.Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын 7058-4647 дугаарын эрх хаагдсан тул Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн санхүүжилтээр сар бүр 15,000 төгрөгөөр эрхийг сунгах тухай хэлэлцэх,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Нармандах

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Д.Мөнхтуяа,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Ч.Оюунаа нарт.

1.1.Мэргэжлийн хяналтын газраас тавигдсан стандарт шаардлагыг хангасан "Есүс Христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн Чойбалсан цуглаан" сүмийг эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан үйл ажиллагааг эхлүүлэхийг зөвшөөрөв.

Хоёр.Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

2.1."Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ний газрын тосны тээвэрлэлт хийхээр 25 автомашин ямар компанийн эзэмшлийн автомашин болохыг тогтоох, тухайн компаниас аймгийн Онцгой комисст хүсэлт ирүүлэх, хүсэлтийн дагуу сум, орон нутгаас санал авч дараагийн аймгийн Онцгой комиссын хуралд танилцуулахыг,

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Баяржаргал-д:

2.2.Монгол улсын хилээр хууль бус бараа тээвэрлэлт хийсэн Мост Ази ХХК-ийн тусгай зөвшөөрлийг цуцлуулах тухай хүсэлтийг Улсын онцгой комисст хүргүүлэхийг,

Гурав. Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Ч.Оюунаа,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт:

3.1."ТВЕА ХХК"-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийн дагуу "ДБЭХС ТӨХК-ийн хүчин чадлыг 50МВт-аар өргөтгөх" төслийн газар шороо, барилга угсралтын хэмжилтийн багаж хэрэгслийг ариутгал, халдваргүйжүүлэлт хийн тусгаарлаж 72 цагийн дараа тусгаарлах байрнаас гаргахыг зөвшөөрөв,

Дөрөв.Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

4.1."Дорнод аймгийн Ерөнхий боловсролын сургуулийг 1990, 1989-1991 онд төгсөгчдийн холбоо"-ноос спортын арга хэмжээ зохион байгуулах зөвшөөрөл хүсэх

тухай аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийг хэлэлцэж Улсын онцгой комиссын 2020 оны 25 дугаар хурлын 4.1 дэх заалтын дагуу хүсэлтийг зөвшөөрөхгүй болохыг албан бичгээр уламжлахыг,

Тав.Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

4.1.Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын мэдээлэл хүлээн авах 70584647 дугаарын утсыг 2020 оны 07 дугаар сарын 15-ны өдрөөс 2020 он дуустал сар бүр 15,000 нэгжээр цэнэглэх зардлыг Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн сангаас Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газарт олгохыг,

Зургаа.Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга,

Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Д.Мөнхтуяа,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Ч.Оюунаа,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,

цагдаагийн хурандаа Т.Ганзориг,

Тагнуулын газрын дарга, Онцгой комиссын

гишүүн, хурандаа Б.Бямбаа,

Гаалийн газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Б.Гэрэлт-Од,

Гадаадын харьяатын Зүүн бүс дэх газрын дарга,


Онцгой комиссын гишүүн Д.Төрхүү нарт:

6.1.Аймгийн Онцгой комиссын (COVID)-той холбоотой цомхотгосон хурлын гишүүд хуралд оролцох боломжгүй тохиолдолд аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад мэдэгдэж байхыг,

Долоо.Аймгийн Онцгой комиссын гишүүдэд:

7.1.Тусгаарлалтын байрнаас иргэдийг тусгаарлалтаас гаргахдаа заавал аймгийн Онцгой комиссын хурлын шийдвэрээр гаргахыг тус тус үүрэг болгож байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА  М.БАДАМСҮРЭН

ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ПРОГРАММ,
ТЕХНИК ХАНГАМЖ ХАРИУЦСАН ИНЖЕНЕР,
АХМАД  Э.ГАНЖИГҮҮР